



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2017 оны 06 сарын 27 өдөр

Дугаар 8/326

Мандалговь

Зөвлөл байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.5, Засгийн газрын 2017 оны 151 дүгээр тогтоолын 4 дүгээр заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журмыг хэрэгжүүлэх аймгийн Бичил уурхайн зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Зөвлөлийн дарга: Аймгийн Засаг даргын тамгын газрын дарга
Нарийн бичгийн дарга: ХОХБТХ-ийн ахлах мэргэжилтэн
Гишүүд: ХОХБТХ-ийн дарга
Хууль эрхзүйн хэлтсийн дарга
МХГ-ын дарга
БОАЖГ-ын дарга
Татварын хэлтсийн дарга
Онцгой байдлын газрын дарга
ЭМНДХ-ийн үйлчилгээний тасгийн дарга
ХХҮГ-ын Хөдөлмөр эрхлэлтийн хэлтсийн дарга
Хүний эрхийн үндэсний комиссын Дундговь дахь ажилтан

Хоёр. Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох үйл ажиллагаатай холбоотой хууль тогтоомжийг сурталчилан хэрэгжилтийг хангаж, хяналт тавьж ажиллахыг зөвлөлд үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

0200645